



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 32 25, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@ama.gov.mn,
Цахим хуудас: www.ama.gov.mn

2024.12.02 № 03/2024
танай _____-ны № _____-т

Тендерийн баримт бичиг хянасан тухай

Танай газраас зарласан “ИНД-67 дагуу гэрчилгээждэг ажилтнууд болон эрсдэлтэй ажлын байранд ажилладаг ажилтнуудын эрүүл мэндийн даатгал” ИНЕГ/20240103109 дугаартай тендерийн баримт бичигт “Хаан даатгал” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1-д “...2023 оны байдлаар нөөц сан 9 тэрбум төгрөгөөс багагүй байх. (Санхүүгийн зохицуулах хорооны тодорхойлолт ирүүлэх)...” гэж заасан байна.


Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Даатгалын салбарын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан”-гийн мэдээллээс үзэхэд 2023 оны жилийн эцсийн байдлаар 15 аж ахуй эрхлэгч ердийн даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулсан байх бөгөөд үүнээс 8 аж ахуй эрхлэгчийн нөөц сангийн хэмжээ тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангахаар байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд...хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.” гэж, 16 дугаар зүйлийн 16.1-д “Захиалагч санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1-д “...2023 оны байдлаар нөөц сан 9 тэрбум төгрөгөөс багагүй байх. (Санхүүгийн зохицуулах хорооны тодорхойлолт ирүүлэх)...” гэж заасан шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу боловсруулсан байна.

Иймд тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Э.ЭРДЭНЭЦЭЦЭГ